



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 32 дугаар хуралдааны тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсээс хийсэн гүйцэтгэлийн шалгалтын тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, мөн Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн 2024 оны гүйцэтгэлийн шалгалтын төлөвлөгөөний дагуу “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” тогтоолын биелэлтийг хангуулах зорилгоор 8 төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, 23 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газар, нийт 31 хуулийн этгээдэд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийв.

Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар газар эзэмших эрхийг бүртгэхтэй холбоотой 170 нэгж талбарын 1,359.7 га газрыг 14.34 тэрбум төгрөгийн зөрчлийг, хөрөнгийн хөдлөл өөрчлөлттэй холбоотой 2,360 нэр төрлийн 28.74 тэрбум төгрөгийн зөрчлийг, мөнгөн хөрөнгөтэй холбоотой 159.6 сая төгрөгийн зөрчлийг нийт давхардсан тоогоор 45 хуулийн этгээд 10 арга хэмжээний 43.23 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгасан байна.

Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагчийн “Ажил эрчимжүүлэх тухай” 4 албан шаардлага, “Хариуцлага тооцох” 2 албан шаардлага, “Журам хүчингүй болгох” 1 албан шаардлага, нийт 7 албан шаардлагыг хэрэгжилт хангалтгүй дүгнэгдсэн хуулийн этгээдэд хүргүүлсэн.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалын дагуу үнэлэхэд 19 байгууллага “Бүрэн хэрэгжсэн”, 9 байгууллага “Хэрэгжих шатанд”, 1 байгууллага “Хэрэгжилт хангалтгүй”, 2 байгууллага “Хэрэгжээгүй” буюу дундаж үнэлгээ 82.6 хувь байгаа тухай танилцуулав.

Д/д	Хуулийн этгээдийн нэр	Тогтоолын огноо/ дугаар	Гүйцэтгэлийн шалгалтын үнэлгээ/хувь	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалын дагуу хүрсэн түвшин
Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага				
1	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	2023/842	90	Бүрэн хэрэгжсэн
2	Эрүүл мэндийн яам	2023/773	90	Бүрэн хэрэгжсэн

3	Эрчим хүчний яам	2024/53	89	Хэрэгжих шатанд
4	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	2023/562	80	Хэрэгжих шатанд
5	Зам, тээврийн яам	2024/772	78.4	Хэрэгжих шатанд
6	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	2023/771	77.1	Хэрэгжих шатанд
7	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	2024/54	0	Хэрэгжээгүй
8	Харилцаа холбооны зохицуулах хороо	2023/561	100	Бүрэн хэрэгжсэн
Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газар				
9	"Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК	2023/770	100	Бүрэн хэрэгжсэн
10	"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК	2024/105	99	Бүрэн хэрэгжсэн
11	"МИАТ" ТӨХК	2023/522	98.1	Бүрэн хэрэгжсэн
12	"Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨҮГ	2023/764	97.1	Бүрэн хэрэгжсэн
13	"Төрийн орон сууцны корпораци" ТӨХК	2023/525	97	Бүрэн хэрэгжсэн
14	"Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	2023/769	97	Бүрэн хэрэгжсэн
15	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	2024/103	96.3	Бүрэн хэрэгжсэн
16	"Диспетчерийн үндэсний төв" ТӨХК	2024/106	95.5	Бүрэн хэрэгжсэн
17	"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК	2024/104	95	Бүрэн хэрэгжсэн
18	"Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК	2023/841	91.5	Бүрэн хэрэгжсэн
19	"Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ	2024/56	91.2	Бүрэн хэрэгжсэн
20	"Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК	2023/575	91.2	Бүрэн хэрэгжсэн
21	"Мэдээлэл технологийн үндэсний парк" ТӨҮГ	2023/843	90.4	Бүрэн хэрэгжсэн
22	"Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ	2023/524	90	Бүрэн хэрэгжсэн
23	"Налайхын дулааны станц" ТӨХК	2023/526	90	Бүрэн хэрэгжсэн
24	"Дулааны хоёрдугаар цахилгаан станц" ТӨХК	2024/57	90	Бүрэн хэрэгжсэн
25	"Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК	2024/78	87.5	Хэрэгжих шатанд
26	"Монгол шуудан" ХК	2024/526	82.2	Хэрэгжих шатанд
27	"Багануурын дулааны станц" ТӨХК	2023/765	81.8	Хэрэгжих шатанд
28	"Дулаан шарын гол" ТӨХК	2023/766	81.1	Хэрэгжих шатанд
29	"Амгалан дулааны	2024/55	70	Хэрэгжих шатанд

	станц" ТӨХК			
30	"Монгол Кувейтын байгаль хамгаалах төв" ТӨҮГ	2023/523	44.1	Хэрэгжилт хангалтгүй
31	"Монголын цахилгаан холбоо" ХК	2024/107	0	Хэрэгжээгүй
Үнэлгээний дундаж хувь			82.6	Хэрэгжих шатанд

Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар 100 хувь буюу "Бүрэн хэрэгжсэн" гэж дүгнэгдсэн Харилцаа холбооны зохицуулах хороо, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК нь шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай тогтоолын заалт бүрээр болон төрийн өмчийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалт, ашиглалтыг сайжруулан, компанийн үр ашгийг дээшлүүлж, илэрсэн зөрчил дутагдлыг заасан хугацаанд арилгаж, хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэн холбогдох арга хэмжээг тухай бүр авч ажилласныг сайшаан онцлов.

Цаашид зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх талаар арга хэмжээ авч, хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахыг Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага болон гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгов. гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

